

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 18 дугаар тогтоол, Улсын Их Хурлын 2024 оны “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 05 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт болон Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 22 дахь илтгэлд тусгасан дүгнэлт, зөвлөмжид нийцүүлж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, түүнд нийцүүлж хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулсан болно.

Хуулийн төсөлд дараах өөрчлөлтийг тусгалаа. Үүнд:

Хүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл байгаа бол түүнийг гэрчээр дуудах, эсхүл түүнээс гэрчийн мэдүүлэг авахгүй байх, гэрчийн мэдүүлэг авах үед түүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрсэн бол гэрчийн мэдүүлэг авахыг даруй зогсоох зохицуулалтын талаар:

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 11 сарын 4-ний өдрийн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлийн зарим хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 10 дугаартай дүгнэлтийн 3-т “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхийг үндэслэлгүй хязгаарласан шинжгүй, хууль зүйн процессын суурь зарчмуудад нийцсэн байх ёстой. Энэ утгаараа хуульд гэмт хэрэгт сэрдэгдэж байгаа этгээдийн эрх зүйн байдлыг дээрх хуулиар нарийвчлан зохицуулж өгөөгүйн улмаас тухайн этгээдээс гэрчийн мэдүүлэг авч, түүний эрхийг хөндөх байдал гаргахаар байгааг хууль тогтоогч анхаарч, хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага байна...” гэж дүгнэсэн.

Илтэд сэжиглэх үндэслэл бүрдсэн байтал түүнд худал мэдүүлбэл хүлээлгэх ял хариуцлагын талаар урьдчилан сануулж, мөн мэдүүлэг өгөхөөс татгалзах, зайлсхийсэн тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 15.7 дугаар зүйлд зааснаар хариуцлага хүлээх талаар мөрдөн шалгах ажиллагаанд урьдчилан сануулж мэдүүлэг авах, энэ нь гэрчийн мэдүүлгийн маягт загварт тусгагдсан байдаг нь хүн өөрийгөө өмгөөлөх, өөрийн эсрэг мэдүүлэг өгөхийг албадуулахгүй байх, мөн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхэд шууд харшилж байгаа болно. Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-аас 1966 онд баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14/3/ г-д “өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, гэм буруутан гэж хүлээхийг албадуулахгүй байх” эрхийг баталгаажуулсан.

Хүнийг гэмт хэрэгт сэжиглэх илэрхий, хангалттай үндэслэл байсаар атал гэрчээр мэдүүлэг авсаны дараа баривчлах, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар

татах тогтоол үйлдсэний дараа сэжигтэн болгох нь Үндсэн хуулиар баталгаажсан “өөрийгөө өмгөөлөх” эрх, “өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байх тул гэрчээр мэдүүлэг авч байх үед гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл тогтоогдвол мэдүүлэг авах ажиллагааг зогсоож, сэжигтнээр мэдүүлэг авах ажиллагааг хуульд заасны дагуу явуулах зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

Иймд гэрчийн мэдүүлэг авах үед түүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрсэн бол гэрчийн мэдүүлэг авахыг даруй зогсоож, сэжигтнээр мэдүүлэг авах ажиллагааг хуульд заасны дагуу явуулах зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.3 дугаар зүйлд тусгалаа.

Хүний халдашгүй байх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах хүрээнд мөрдөн байцаалтыг өмгөөлөгчийг байлцуулахгүйгээр явуулахгүй байх, хэрвээ өмгөөлөгчийг байлцуулахгүйгээр мөрдөн байцаалт явуулж нотлох баримт цуглуулсан, хэрэг хүлээлгэсэн тохиолдолд тухайн мэдүүлэг, нотлох баримтыг үнэлэхгүй байх зохицуулалтын талаар:

Практикт мэдүүлэг авах ажиллагааг өмгөөлөгчгүйгээр явуулж, хууль бусаар хэрэг хүлээлгэх, өөрийнх нь эсрэг мэдүүлэг авах тохиолдлууд цөөнгүй гарч байгаатай холбоотойгоор өмгөөлөгч оролцуулах хүсэлт гаргасан бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагаанд өмгөөлөгч заавал оролцуулах асуудлыг хуулиар баталгаажуулах шаардлага тулгараад байна.

Иймд хүний халдашгүй байх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах хүрээнд өмгөөлөгч оролцуулах хүсэлт гаргасан тохиолдолд өмгөөлөгчгүйгээр мөрдөн байцаалт явуулахгүй байх нэмэлтийг тусгалаа.

Ингэснээр Үндсэн хуульд заасан “хууль зүйн туслалцаа авах” эрхийг хангаж, мэргэжлийн туслалцаа үзүүлэх үүргийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шатанд тасралтгүй хэрэгжүүлэх, хүний эрхийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, хүний эрхийг хамгаалахад үр нөлөөтэй бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль ёсны зарчмыг хэрэгжүүлэх гол нөхцөл болно.

Шүүх хуралдаан хойшлох асуудлын талаар:

Шүүх хуралдаан хойшилж буй шалтгаан нөхцөлийн дийлэнх нь өмгөөлөгчтэй холбоотой болох нь шүүхийн практикт хийсэн судалгаагаар харагддаг.

Өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах, өмгөөлүүлэх эрхээр хангагдах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчтэй оролцох нь яллагдагч, шүүгдэгч, хохирогч, гэрчийн хувьд Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар баталгаажуулсан үндсэн эрхийн нэг юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийн оролцоог хангах нь хүн хилсээр ял шийтгэгдэхгүй байх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуульд заасан журмын дагуу явагдах чухал баталгаа юм.

Шүүх хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа хойшлуулж байгаа нөхцөл байдлыг хязгаарлах үүднээс өмгөөлөгчид хариуцлага тооцох зохицуулалтыг тусгасан бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, хариуцлага хүлээлгэх талаарх мэдээллийг Монголын өмгөөлөгчдийн холбоонд

даруй хүргүүлэхээр тусгалаа. Тус зохицуулалт нь улсын яллагчид мөн хамаарах бөгөөд энэ тохиолдолд харьяалах прокурорын байгууллагад мэдэгдэж, мэдээллийг даруй хүргүүлэхээр зохицуулсан болно.

Түүнчлэн шүүгдэгчийн гэм буруутай эсэхийг хянан хэлэлцэх үндсэн шүүх хуралдааны бэлтгэлийг талуудын оролцоотой хангаж, шүүх хуралдаан хойшлогдох явдлыг багасгах зорилгоор 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах журмыг шинээр хуульчилсан бөгөөд мөн хуулийн 33.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт “Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт оролцох хүсэлт гаргасан тохиолдолд хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг оролцуулж болно. Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч ирээгүй нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй.” гэж заасан.

Ийнхүү шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг шүүх нэг удаа явуулах агуулгаар дээрх заалтыг хуульчилсан боловч хуулийн буруу хэрэглээ тогтож, оролцогч ирээгүй нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг удаа дараа хойшлуулах шалтгаан болсоор байна.

Иймд прокурор, оролцогч ирээгүй нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй байх зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлд тусгалаа.

Түүнчлэн шүүгдэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй тохиолдолд шүүх хуралдааныг хойшлуулахгүй бөгөөд шүүгдэгч шүүх хуралдаанд оролцож, шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэг өгөх эрхээ эдэлсний дараа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдааныг орхин явж, шүүх хуралдаанд оролцохоос санаатай зайлсхийсэн бол шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулж, гэм буруутай эсэхийг эцэслэн шийдвэрлэхээр тусгалаа. Шүүгдэгчийн эзгүйд шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулахад шүүгдэгчийн өмгөөлөгчийг оролцуулна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүх хуралдааныг хойшлуулахад талуудын санал, хүсэлтийг харгалзан дараагийн шүүх хуралдааны товыг тогтоож, хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээг авна.” гэж заасан ба шүүхийн практикт шүүх хуралдааныг 1 сар, түүнээс илүү хугацаагаар хойшлуулах явдал гарсаар байна.

Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх ашигт сөргөөр нөлөөлж байх тул шүүх хуралдааныг 14 хүртэл хоногийн хугацаагаар хойшлуулдаг практик тогтоож хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэн, шуурхай явуулах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар “...Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.9 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт болон 40.8 дугаар зүйлийн 1.3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсон” бөгөөд анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанаас хэргийг прокурорт буцаах, түүнчлэн давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг дахин хэлэлцүүлэхээр доод шатны шүүхэд буцаах эрх хэмжээгүй болсон.

Зөвхөн анхан шатны шүүх хуралдааны явцад нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэн шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэх шаардлагатай болсон, эсхүл хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад

оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан болон нотлох баримт цуглуулж, бэхжүүлэхэд хуульд заасан журам зөрчигдсэн талаар талуудын гаргасан гомдлыг шийдвэрлэх шаардлагатай нөхцөлд шүүх хуралдааныг нэг удаа 60 хүртэл хоногийн хугацаагаар хойшлуулж, шаардлагатай ажиллагаа явуулахыг прокурорт даалгах замаар мөрдөн байцаалтын шатанд гарсан хууль хэрэглээний алдааг зөвтгөх зохицуулалт үйлчилж байна.

Хэргийн бүрдэл хангагдаагүй буюу мөрдөн шалгах ажиллагааны явцад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд заасан нотолбол зохих байдлыг дутуу шалгасан, хэрэгт цугларсан нотлох баримтууд нь гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдлыг хөдөлбөргүй тогтооход хүрэлцэхүйц байх нотолгооны стандартыг хангаагүй, түүнчлэн мөрдөн байцаалтын шатанд оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан болон нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар хуульд заасан журам зөрчсөн алдааг шүүхийн шатанд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлийн 5, 6, 7 дахь хэсэгт заасан журмын дагуу 60 хоногт багтаан нөхөн гүйцэтгэх боломжгүй, хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэн өөрчилж, эсхүл зарчмын өөр агуулгатай ял сонсгох шаардлагатай нөхцөлд хуулийн зорилт, нийтлэг зарчмуудад нийцүүлэн холбогдох өөрчлөлтийг тусгах шаардлага үүсээд байна.

Иймд шүүх хуралдааны явцад нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэн шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэхээр бол, эсхүл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6.13, 6.14-т заасан гомдлыг шийдвэрлэх зорилгоор шүүх хэргийг хянан хэлэлцэхийг зөвхөн нэг удаа 60 хүртэл хоногийн хугацаагаар хойшлуулдаг байсан зохицуулалтыг өөрчилж, шүүхээс даалгасан ажиллагааг прокурор шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлэх боломжгүй бол шүүх хуралдааныг 60 хүртэл хоногоор хойшлуулсаныг дахин 30 хүртэл хоногоор нэмж хойшлуулах зохицуулалтыг тусгалаа.

Олон оролцогчтой хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг тогтоохтой холбогдсон зохицуулалтын талаар:

Тухайн хэргийн ээдрээ төвөгтэй байдал, эсхүл ажиллагаа ихтэй, олон яллагдагчтай, эсхүл олон үйлдэлтэй зэрэг нөхцөл байдлыг харгалзан шаардлагатай тохиолдолд мөрдөн байцаалт явуулах хугацааг сунгаж болох зохицуулалтыг хуульчилсан боловч олон оролцогчтой хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг хэрхэн, ямар журмаар явуулах нь тодорхойгүй байх тул тус хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг олон улсын сайн туршлагыг судалсны үндсэн дээр нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

Практикт хэд хэдэн өмгөөлөгчтэй шүүх хуралдаанд нэг агуулга бүхий асуудлаар өмгөөлөгч бүр мэтгэлцэх, цаг хугацаа алдах, улмаар шүүх хуралдаан хойшлох явдал гарсаар байна.

Иймд шүүгдэгчийг хэд хэдэн өмгөөлөгч өмгөөлж байгаа бол шүүх хуралдаанд тодорхой асуудлаар мэтгэлцэхэд нэг өмгөөлөгч бусдыгаа төлөөлж болох зохицуулалт байсныг шүүх хуралдаанд мэтгэлцэхэд заавал нэг нь бусдыгаа төлөөлөх императив шинжтэй зохицуулалт болгож өөрчлөв.

Түүнчлэн шүүх хэд хэдэн шүүгдэгчид холбогдох хэрэгт шүүгдэгчийн хууль ёсны ашиг, сонирхол хөндөгдөхгүй шүүхийн хэлэлцүүлэг явагдах үед шүүх хуралдааны танхимд байлцахгүй байх талаар оролцогчийн гаргасан хүсэлт,

талуудын саналыг харгалзан шийдвэрлэх, тус хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн бол энэ тухай шүүх хуралдааны тэмдэглэлд тусгаж, шүүх хуралдаанд үргэлжлүүлэн оролцох товыг оролцогчид мэдэгдэх нэмэлтийг тусгалаа.

Хавтаст хэргийг цахимжуулах, цахим суурьтай нотлох баримтыг шүүх хуралдаанд шинжлэн судлах, цахим суурьтай нотлох баримтыг үнэлэх журмын талаар:

Хавтаст хэргийг цахимжуулах, цахим хэрэгсэл ашиглаж нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, хадгалах, үнэлэх хэрэгцээ, шаардлага нь өнөө цагт тулгамдсан асуудал болж байгаа бөгөөд тус ажиллагааг процессжуулах, хуульчлах хэрэгцээ, шаардлага тулгараад байна.

Тухайлбал, олон оролцогчтой хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд прокурорын яллах дүгнэлтийг хуулбарлан гардуулж өгөхөд ихээхэн зардал, цаг хугацаа шаардагддаг.

Иймд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар тус хуулийн 11.11 дүгээр зүйлд “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, хэргийн материал нь цаасан болон цахим хэлбэртэй байж болно.” гэсэн зохицуулалтыг нэмж хуульчилсан.

Түүнчлэн шүүх, прокурор, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг үйлдэх, шийдвэр гаргах, хэргийн оролцогчтой харилцах, хэргийн материалыг оролцогчид танилцуулах, баримт бичиг хүлээн авах, хүргэх болон шүүх хуралдаан, шүүхийн хэлэлцүүлэг явуулах ажиллагааг цахим платформ ашиглан явуулж болох зохицуулалтыг хуульчилсан.

Хавтаст хэргийг цахимжуулах нь цаасан суурьтай бичиг баримт, нотлох баримтыг боловсруулахад шаардагдах зардал, цаг хугацааг бууруулах ач холбогдолтой юм.

Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа цахим хэлбэрт шилжсэнээр зарим хэрэг, маргааныг богино хугацаанд хянан шийдвэрлэх замаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалагдаж, шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшилж, иргэд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран үйлчилгээг шат дамжлагагүй, шуурхай авах нөхцөл бүрдэнэ.

Шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй, ил тод байх, шүүх хуралдааныг цахимаар нэвтрүүлэх эрх зүйн үндэслэлийг Монгол Улсын шүүхийн тухай хуулиар зохицуулсан хэдий ч тус асуудлыг хэрхэн хэрэгжүүлэхтэй холбогдох журам гараагүй буюу өмнөх хуулийн хүрээнд мөрдөж байсан хуучин журмууд хүчин төгөлдөр хэвээр байна. Энэхүү журмаар шүүхийн зүгээс шүүх хуралдааныг шууд дамжуулах бус өргөн нэвтрүүлгийн буюу хэвлэл мэдээллийн байгууллага, тэдгээрийн ажилтан дамжуулахтай холбогдох асуудлыг журамласан байх бөгөөд төр, байгууллага, хувь хүний нууц, насанд хүрээгүй этгээдэд холбогдох эрүү, иргэн, захиргааны хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүх хуралдааныг цахимаар мэдээлэхийг хоригложээ. Иймд шүүхийн үйл ажиллагааны олон нийтэд нээлттэй, ил тод байдлын хэлбэрүүдийг тодорхойлох, тэдгээрийг биечлэн болон цахимаар хэрхэн хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалт, түүнчлэн хэргийн оролцогчид хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн ажиллагаа цахимаар нээлттэй, ил тод байх, үүнийг

хэрхэн, ямар ажиллагаанд хэрэгжүүлэх зэрэг талаар хуульчлах шаардлага үүсээд байсан.

Ийнхүү 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар төрийн нууцад хамаарах хэрэг хянан шийдвэрлэх, хуульд тусгайлан зааснаас бусад шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг нээлттэй явуулах зохицуулалтыг хуульчилсан.

Түүнчлэн тус хуулиар хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын яллагч, хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нээлттэй, эсхүл хаалттай явуулах эсэхийг шүүх шийдвэрлэхээр зохицуулсан.

Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүх, прокурорын шийдвэрийг оролцогчид танилцуулах, гардуулан өгөх журмын талаар:

Шүүх хуралдааныг нээлттэй, хаалттай явуулсан, шүүхийн шийдвэрт төрийн болон албаны нууц мэдээлэл агуулагдсан эсэхээс үл хамаарч прокурор, оролцогчийг шүүхийн шийдвэр, түүний үндэслэлтэй бүрэн танилцах, уг шийдвэрийг эс зөвшөөрвөл эсэргүүцэл, гомдол гаргах эрхийг баталгаатай хангах нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан "... шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх..." хүний үндсэн эрхтэй салшгүй холбоотой билээ.

Шүүхийн шийдвэрийг оролцогчид гардуулах харилцааг журамласан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.5 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, 36.13 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 39.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 40.8 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн зохицуулалтаас үзэхэд төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан шийдвэрийг оролцогчид хэрхэн танилцуулах, эсхүл гардуулах асуудлыг хуульд нарийвчлан заахгүй орхигдуулжээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг баримтална." хэмээн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зөвхөн эрүүгийн процессын хуулийг баримтлах зарчмыг хуульчлан заасан тул төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийг прокурор, оролцогчид гардуулах, танилцуулах талаар эрүүгийн процессын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, тухайн харилцааг нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

Иймд төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүх, прокурорын шийдвэрийг оролцогчид танилцуулах, гардуулан өгөх журмыг нарийвчлан тодорхойллоо.

Шинээр нэгтгэсэн хэрэгт цагдан хоригдсон хугацааг тусад нь тоолох зохицуулалтын тухайд:

Мөрдөн шалгах ажиллагааны явцад дахин гэмт хэрэг үйлдэж, цагдан хоригдсон тохиолдолд цагдан хорих хугацааг тусад нь тоолох эсэх нь тодорхой

зохицуулагдаагүй байх тул энэ тохиолдолд цагдан хорих хугацааг шинээр тоолохоор тусгах нь зүйтэй.

Иймд шинээр нэгтгэсэн хэрэгт цагдан хоригдсон хугацааг тусад нь тоолох, харин хорих ял эдэлж байгаа ялтанд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан үед хорих ялын хугацаа дуусахаар бол хуульд заасны дагуу цаашид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг шүүх шийдвэрлэхээр тусгалаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах нөхцөл боломжийг бий болгох, 6-аас дээш сар хадгалах эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар:

Мөрдөн шалгах ажиллагааны үр дүнг бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг хавтаст хэрэгт нотлох баримтаар хавсаргаж, хэргийн хамт хадгалагддаг. Ингэхдээ хэргийн оролцогчоос мэдүүлэг авах процессыг бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг ямар хугацаанд хэрхэн хадгалах талаар зохицуулаагүй байна.

Иймд мэдүүлгийн тэмдэглэлүүд дууны болон дуу-дүрсний бичлэгээс зөрөх тохиолдол практикт гардаг бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.7 дугаар зүйлийн 2-т “Мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын хянан шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэлд тусгагдсан нөхцөл байдал нь дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгээс зөрсөн тохиолдолд шүүх, прокурор дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг нотлох баримтаар тооцно.” гэж заасан тул бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хувийг хавтаст хэргийн хамт хадгалах зохицуулалтыг тусгалаа.

Өмгөөллийн тухай хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийн эрх, үүргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмж тусгах талаар:

Өмгөөллийн үйл ажиллагаанд эдлэх эрх, үүргийг холбогдох хэрэг хянан шийдвэрлэх хуулиудаас гадна өмгөөлөгчийн бүрэн эрхийн заалт Өмгөөллийн тухай хуульд тусгалаа олсон.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд хамаарах Өмгөөллийн тухай хуульд заасан зарим эрх процессын хуульд тодорхой тусгагдаагүйгээс мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэгчийн зүгээс хуулийн зохицуулалтыг зөрүүтэй ойлгох, хууль зүйн туслалцаа үзүүлэх үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэх, хэргийн бодит байдлыг тогтооход чухал ач холбогдол бүхий баримтыг шүүхэд гарган өгөх боломжгүй болох тохиолдлууд гарч байх тул эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийн эрх, үүргийг Өмгөөллийн тухай хуулийн зохицуулалттай уялдуулан тусгалаа. Тухайлбал, хууль зүйн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч, прокуророос гадна шүүхэд гаргаж өгөх, түүнийг хавтаст хэрэгт бэхжүүлж тусгуулах, хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг шалгуулах, хуульд заасан дүрэм, журмын дагуу хуулбарлан авах зорилгоор зураг, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн болон бусад техник хэрэгсэл ашиглах эрхээр хангагдахаар тусгалаа.

Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч сэжигтнийг баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээ авах болсон

үндэслэлд хамаарах нотлох баримттай танилцах, таслан сэргийлэх арга хэмжээ авах шүүхийн хэлэлцүүлгийг талуудын мэтгэлцээний үндсэн дээр явуулах зохицуулалтын тухайд:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь яллах болон өмгөөлөх талуудын тэгш эрхийн зарчим дээр тулгуурласан мэтгэлцээний үндсэн дээр явагддаг байх ёстой. Мэтгэлцээн нь шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны явцад шүүхээс гарах аливаа шийдвэрийн үндэслэл болохын зэрэгцээ шүүгч талуудын мэтгэлцэж буй байдалд дүгнэлт хийж шийдвэрээ хөндлөнгийн хараат бусаар гаргах учиртай.

Гэтэл Хүний эрхийн Үндэсний Комиссын хийсэн судалгаагаар шүүхийн хэлэлцүүлэг үр дүнтэй явагддаггүй, шүүх мэтгэлцээнд үндэслэсэн хөндлөнгийн шийдвэр гаргадаггүй, өмгөөлөгчийн оролцоо хангалтгүй байгаа нь тогтоогдсон. Тодруулбал, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, хугацаа сунгах эсэхийг шийдвэрлэх шүүхийн хэлэлцүүлэгт “өмгөөлөгчийн оролцоо, мэтгэлцэх зарчим хангагдаж байгаа эсэх” талаар судалгаанд оролцсон шүүгч, прокуроруудын 46 хувь нь “дунджаас дээгүүр” гэж хариулсан бол “хангалттай сайн” гэж шүүгчдийн 3.8 хувь, прокуроруудын 10.3 хувь нь тус тус үзжээ. Харин өмгөөлөгчдийн 72.1 хувь нь “өмгөөлөгчийн оролцоо туйлын хангалтгүй” байдаг талаар дурджээ.¹

Өмгөөлөгчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хэлэлцүүлэгт оролцох өмгөөлөгчийн оролцоо хангалтгүй, өмгөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлж чадахгүй байгаа шалтгааныг “цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахаар гаргаж буй саналын үндэслэл, түүнийг нотолсон нотлох баримттай өмгөөлөгчийг танилцуулдаггүй, талуудыг мэтгэлцэх боломж олгодоггүй” гэж тайлбарлаж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.3 дугаар зүйлд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нууцлал гэх зүйлийн 1 дэх хэсэгт “Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага, албан тушаалтан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын төлөвлөлт, явц, үр дүнгийн нууцлалыг хангаж ажиллана”, мөн зүйлийн 5 дахь хэсэгт “Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын материалыг прокурорын зөвшөөрснөөр, прокурорын мэдэгдэх бололцоотой гэж үзсэн хэмжээгээр нийтэд мэдэгдэж болно”, мөн хуулийн 32.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “мөрдөгч мөрдөн шалгах бүх ажиллагааг хийж дууссан, хэргийн бодит байдлыг бүрэн нотолж тогтоосон гэж үзвэл яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид хавтаст хэргийн материалтай танилцахыг мэдэгдэнэ” гэж тус тус заажээ. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг ихэвчлэн мөрдөн байцаалтын шатанд авдаг бөгөөд мөрдөн байцаалтын ажиллагаа дусаагүй гэх шалтгаанаар цагдан хорих арга хэмжээ авах, сунгах, өөрчлөх үндэслэл болж буй нотлох баримтыг өмгөөлөгчид танилцуулдаггүй, мөрдөн шалгах ажиллагааны нууц алдагдах гэсэн шалтгаанаар хаалттай бөгөөд эргэлзээтэй байдлаар шүүхийн хэлэлцүүлэг явагдаж байгаа нь НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан ажлын хэсгийн урьдчилсан дүгнэлтэд мөн дурдагджээ.

Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч сэжигтнийг баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээ авах болсон үндэслэлд хамаарах нотлох баримттай танилцах боломжоор хангадаггүй, таслан сэргийлэх

¹ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, URL: <https://nhrcm.gov.mn/assets/img/58c1302622c8c88d036544f656fdff5d.pdf>

арга хэмжээ авах шүүхийн хэлэлцүүлэг мэтгэлцээний үндсэн дээр явагдахгүй, нотлох баримтыг ил тод хэлэлцдэггүй, цагдан хорих арга хэмжээ авагдаж байгаа хүнийг өмгөөлүүлэх эрхээр бүрэн хангахгүй байгаа нь ИБУТЭТОУП-ын 3 дахь хэсэгт заасан агуулгад хамаарх “Шүүхийн анхны хэлэлцүүлэг, дараагийн шатны шүүх хурлаар хүнийг цагдан хорьсон нь хууль ёсны, үндэслэлтэй эсэхийг хянан хэлэлцэхэд хоригдож буй этгээд хууль зүйн туслалцаа авах, зарчмын хувьд өөрийн сонгосон өмгөөлөгчөөр эрх ашгаа хамгаалуулах эрхтэй” мөн 4 дэх хэсэгт заасан “ ... цагдан хоригдож эрх чөлөөгөө хасуулсан хүн бүр ийнхүү хорьж саатуулсан нь хууль ёсны эсэхийг шүүхээр даруй тогтоолгох, хууль бусаар хорьсон бол суллуулах шийдвэр гаргуулах эрхтэй”, мөн пактын 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй” гэсэн заалтад нийцэхгүй байна.

Иймд мөрдөн шалгах ажиллагаанд хүний эрхийн зөрчил гарахаас урьдчилсан сэргийлэх зорилгоор сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг сэжигтнийг баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээ авах болсон үндэслэлд хамаарах нотлох баримттай танилцуулах замаар шүүхийн хэлэлцүүлгийг талуудын мэтгэлцээний үндсэн дээр явуулах боломжийг хангах зохицуулалтыг тусгалаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд яллах, өмгөөлөх талын эрх тэгш мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх талаар:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Шүүх хуралдаан даргалагч нь шүүхийн хэлэлцүүлгийг яллах, өмгөөлөх талын эрх тэгш мэтгэлцээний үндсэн дээр явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж заасан нь зөвхөн анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд хамаарах зохицуулалт гэж ойлгогдож байх тул яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авах шүүхийн хэлэлцүүлгийг мөн талуудын эрх тэгш мэтгэлцээний үндсэн дээр явуулах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн, бодит байдал дээр мөрдөн байцаалтыг дуусгаж, хэргийн материалтай танилцах хангалттай хугацааг өмгөөлөгчид олгохгүйгээр дараагийн шатанд шилжүүлэх тохиолдол түгээмэл байдаг тул Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлд “3(b).Хүн бүр өөрийг нь яллагдагчаар татсан аливаа эрүүгийн хэргийг хянан хэлэлцэхэд бүрэн тэгш эрхийн үндсэн дээр өмгөөлүүлэх ажлаа бэлтгэх хүрэлцээтэй хугацаа, бололцоотой байх, сонгож авсан өмгөөлөгчтэйгээ харилцах баталгаагаар хангагдах эрхтэй” гэж заасантай нийцүүлэн хэрэг танилцуулах боломжит хугацааг тодорхойллоо. Тухайлбал, оролцогч хэргийн материалтай 14 хүртэл хоногийн хугацаанд танилцах ба мөрдөгч хэргийн материалтай танилцах боломж, нөхцөлийг бүрдүүлэх бөгөөд тухайн хэргийн онцлогоос хамаарч тус хугацааг мөрдөгч 14 хүртэл хоногоор сунгаж болохоор тусгалаа.

Мөрдөгч, прокурор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан яллагдагч, шүүгдэгчийг цагаатгах, хэргийг хөнгөрүүлэх нөхцөл байдлыг нотлох чиг үүргээ хэрэгжүүлээгүй бол яллагдагч, шүүгдэгч энэ талаарх нотлох баримтыг шүүхэд гаргах эрхтэй байх талаар:

Анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тухайн шүүгдэгчийн хувьд прокуророос шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэргийн хүрээнд явагдахаар хуульчлагдсан бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа прокурорын удирдлага, хяналтад явдаг, өмгөөлөгчийн зүгээс гаргадаг нэмэлт нотлох баримт

цуглуулахтай холбоотой хүсэлтийг хангалттай шийдвэрлэдэггүй тул өмгөөлөх тал шүүхэд нэмэлт нотлох баримт гаргаж өгөх боломжийг нээсэн зохицуулалтыг тусгалаа.

Хүн ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх эрхийг хангах хүрээнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан талаарх тогтоолыг гардуулан өгөх зохицуулалтын талаар:

Манай улсын нэгдэн орсон хүний эрхийн талаарх олон улсын баримт бичгүүд болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх эрхийг баталгаажуулсан. Энэхүү эрхийн хэрэгжилтийг бодитойгоор хангах хүрээнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татагдсан тогтоолын хувийг авах эрхийг яллагдагчид олгох нь зүйтэй байна. Олон үйлдэлтэй, мөн эрүүгийн хуулийн тусгай ангид заасан олон зүйл хэсэгт буруутгагдаж байгаа хүний тухайд яллагдагчаар татах тогтоол хэдэн зуун хуудастай, шууд танилцаж, юунд буруутгагдаж байгаагаа ойлгоход төвөгтэй байдгаас хуулиар баталгаажсан эрхийг нь хангах боломж хязгаарлагддаг. Иймд мөрдөгч энэхүү тогтоолын хувийг гардуулан өгөх талаарх зохицуулалтыг тусгалаа.

Шүүх, прокурор, мөрдөгч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан хүсэлтийг хангахаас татгалзаж байгаа үндэслэлийг тухайн шийдвэртээ тодорхой тусгах талаар:

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокуророос гарч байгаа, тэр тусмаа мөрдөн шалгах ажиллагаа явуулах, нотлох баримттай холбоотой шийдвэрүүд хууль зүйн болон нотолгооны үндэслэлтэй байх зайлшгүй шаардлагатай. Дээрх асуудлаар хэргийн оролцогчоос гаргасан хүсэлтийг шийдвэрлэхдээ прокурор, мөрдөгч хангаагүй, татгалзсан үндэслэлээ тодорхой заахгүй, зөвхөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байгаа талаарх хариу өгч хэвшсэн байна. Энэ нь Үндсэн хуульд заасан "... албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага албан тушаалтан нь иргэдийн өргөдөл гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй" гэсэн заалтыг бодитоор хэрэгжих боломжийг хааж, үндэслэлгүй, ёс төдий, ажил хэрэгч бус хандлагыг бүрдүүлж байна.

Иймд хүсэлтийг хэсэгчлэн хангасан эсхүл хангахаас татгалзаж байгаа үндэслэлийг тухайн шийдвэртээ тодорхой тусгах зохицуулалтыг тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч байсан хүндрэл бэрхшээл арилж, Монгол Улсын Үндсэн хуульд заасан халдашгүй, чөлөөтэй байх үндсэн эрх улам бүр баталгаажиж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцид нийцнэ. Монгол Улсын Үндсэн хуульд заасан "хууль зүйн туслалцаа авах" эрх улам бүр баталгаажна.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад хүний эрхийн зөрчил гарахаас урьдчилсан сэргийлэх эрх зүйн орчин боловсронгуй болсноор хүний эрх чөлөөг хангах, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээн эдлүүлэх ажлын үр дүн дээшилнэ.

Түүнчлэн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа цахим хэлбэрт шилжсэнээр зарим хэрэг, маргааныг богино хугацаанд хянан шийдвэрлэх замаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалагдаж, шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшилж, иргэд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран үйлчилгээг шат дамжлагагүй, шуурхай авах нөхцөл бүрдэнэ.

Хуулийн төслийг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/141 тоот тушаалаар байгуулагдсан Эрүүгийн хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, боловсронгуй болгох чиг үүрэг бүхий Байнгын ажлын хэсгийн гишүүдээр хэлэлцүүлсэн болно.

Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр зардал гарахгүй болно.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ